



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Хуулийн төсөл нэн яаралтай хэлэлцүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16¹ дүгээр зүйлийн 16¹.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг Монгол Улсын Ерөнхий сайдын хүсэлтийг үндэслэн хэлэлцэх асуудлын тов, дарааллыг харгалзахгүйгээр Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлсүгэй.

2. Энэ захирамжийн 1-д заасан хууль, тогтоолын төслийг Байнгын болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Б.Чойжилсүрэн/, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Ё.Баатарбилэг/-нд даалгасугай.



0000000086



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

2018 он 01
сарын 30 өдөр

Дугаар 37-1
22

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД ТАНАА

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16¹.1-д заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭДЭТХ



200501



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 он 01 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар ХЭЛ
229

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ц.ЦОЛМОН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон здгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн тул хуулийн төслийг холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Хавсралт²⁴ хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

000235


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны 6 дугаар тэмдэглэлд:

“I.ХЭЛЭЛЦСЭН нь:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн дэмжээд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16¹.1-д заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР




МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг.
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
<http://www.mojha.gov.mn>

2018.01.30 № 1-1/556
таний 2018.01.29 -ны № 4-1/475 -т

САНГИЙН САЙД Ч.ХҮРЭЛБААТАР
ТАНАА

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон дагалдах бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зүйтэй гэж үзэв.


Ц.НЯМДОРЖ

08 0358
Doc.yam ab.2017




МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: 26-74-68, <http://www.mof.gov.mn>


2018.01.30 № 4-1/489
танаи _____ -ны № _____ -т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Хувь хүний орлогын албан татварын тухай
хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн
даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн
тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
болон дагалдах бусад хууль, Улсын Их Хурлын
тогтоолын төслүүдийг төслүүдийг Улсын Их
Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрөв.


Н.ХҮРЭЛБААТАР

00195



ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

УИХ-ын 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, 2018 оноос эхлэн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн орлогод 10-25 хувиар, 4 шатлалтайгаар албан татвар ногдуулахаар болсон.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл тогтвортой өсөж, татварын бааз суурь тэлж, иргэд, аж ахуйн нэгжүүдийн татвар төлөх идэвх, санаачилга дээшилж байна. Иймээс иргэдийн цалин, хөдөлмөрийн хөлсний орлогод ногдуулах татварыг нэг шатлалтай болгож, эдийн засаг дахь татварын ачааллыг бууруулж, татварын системийг энгийн, ойлгомжтой болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь бизнесийн хөгжлийг хурдасгах, хөрөнгө оруулалтыг татах, ажлын байр шинээр бий болгох, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэхэд өндөр ач холбогдолтой байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээз

Энэ хуулийн төслийн зорилго нь иргэд, аж ахуйн нэгжийн татварын ачааллыг бууруулж, татварын бааз суурийг тэлэх болно. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдуулах татварын хэмжээг нэг шатлалтай, 10 хувь болгох болон энэ төрлийн орлогод үзүүлэх татварын хөнгөлөлтийн хэмжээг тодорхойлсон зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.

Гурав. Хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар иргэд, аж ахуйн нэгжийн татварын ачаалал буурч, татвараа шударгаар төлөх идэвх дээшилнэ.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн Хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулсан болно. Хуулийн төсөл батлагдсанаар Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг боловсруулна.

ТАНИЛЦУУЛГА

Хувь хүний орлогын албан татварын тухай
хуульд өөрчлөлт оруулах тухай

УИХ-ЫН 2017 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДРИЙН НЭГДСЭН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНААР ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЖ, 2018 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН 1-НИЙ ӨДРӨӨС ЭХЛЭН ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ОРЛОГОД 10-25 ХУВИАР, 4 ШАТЛАЛТАЙГААР АЛБАН ТАТВАР НОГДУУЛАХААР БОЛСОН.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл тогтвортой өсөж, татварын бааз суурь тэлж, иргэд, аж ахуйн нэгжүүдийн татвар төлөх идэвх, санаачилга дээшилж байна. Нөгөө талаас, дэлхийн зах зээл дээрх уул уурхайн бүтээгдэхүүний үнэ ханш ойрын ирээдүйд харьцангуй тогтвортой, өндөр байх төлөвтэй байна. Энэ нь манай улсын эдийн засаг, төсөвт зерэг нөлөө үзүүлэхээр байна.

Энэхүү нөхцөлд иргэдийн цалин, хөдөлмөрийн хөлсний орлогод ногдуулах татварыг нэг шатлалтай болгож, эдийн засаг дахь татварын ачааллыг бууруулж, татварын системийг энгийн, ойлгомжтой болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь бизнесийн хөгжлийг хурдаасгах, хөрөнгө оруулалтыг татах, ажлын байр шинээр бий болгох, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэхэд өндөр ач холбогдолтой байна гэж үзэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдуулах татварын хэмжээг нэг шатлалтай, 10 хувь болгохоор хуулийн төсөлд тусгасан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэд, аж ахуйн нэгжийн татварын дарамт буурч, татвараа шударгаар төлөх идэвх санаачилга улам дээшлэх бөгөөд бизнесийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт татах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр шинээр бий болгоход зерэг нөлөө үзүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
 хот

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг:

"23.1. Энэ хуулийн 17 дугаар зүйл, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна."

2/24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг:

"24.1. Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ:

Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ /төгрөгөөр/	Албан татварын хөнгөлөлтийн хэмжээ /төгрөгөөр/	
	2018 он	2019 он ба түүнээс хойш
0-6 000 000 хүртэл	160 000	240 000
6 000 000-12 000 000 хүртэл	140 000	220 000
12 000 000-18 000 000 хүртэл	120 000	200 000
18 000 000-24 000 000 хүртэл	100 000	180 000
24 000 000-30 000 000 хүртэл	80 000	160 000
30 000 000-36 000 000 хүртэл	60 000	140 000
36 000 000 ба түүнээс дээш	-	-

3/26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалт:

"26.1.1. Энэ хуулийн 11 дүгээр зүйл, 15.1-д заасан орлогод 23.1-д заасан хувиар, 14.1.1-д заасан орлогын дүнд 23.2.1-д заасан хувиар, 8.1.6, 8.1.7-д заасан орлогын

дүнд 23.2.2-т заасан хувиар, 8.1.8-д заасан орлогын дүнд 23.2.3-т заасан хувиар, 12.2, 13.1.2, 13.1.3, 13.1.4-т заасан орлогын дүнд 23.2.4-т заасан хувиар тус тус албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;"

2 дугаар зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.4 дэх заалтын ", 22.1.4" гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны .. дугаар
сарын...-ны өдөр

Дугаар ...


Улаанбаатар
хот

**ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор УИХ болон ИТХ-аар батлагдсан 2018 оны улс, орон нутгийн төсвийн орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрийг батлагдсан хэмжээнээс нэмэгдүүлэх бүхий л боломжит арга хэмжээг авч, улс, орон нутгийн төсвийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т, Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч наарт даалгасугай;
- Энэ тогтоолыг Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

ГАРЫН ҮСЭГ



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ
БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага

1. Үндэсний статистикийн хорооноос гаргасан "Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо"-оор одоо Монгол эрэгтэй хүний 60 наснаас хойш амьдрах хугацаа 17.06 жил, эмэгтэй хүний 55 наснаас хойш амьдрах хугацаа 25.38 жил байгаа бол энэ үзүүлэлт 2040 онд эрэгтэй 20.94 жил, эмэгтэй 55 наснаас хойш 28.71 жил болж жилд дунджаар 1.6-2 сараар нэмэгдэхээр байна.

Нийгмийн даатгалын болон халамжийн тухай хуулиудад 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан өөрчлөлтөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох насыг жилд 6 сараар буюу таван насаар 65 насанд хүргэхээр шийдвэрлэсэн нь дээрх тооцоололтой харьцуулахад 3 дахин өндөр байхын зэрэгцээ монгол хүний дундаж наслалтын өсөлттэй нийцэхгүй байна. Энэ нь тэтгэвэр тогтоолгох нас ойртож, хүлээлт үүссэн даатгуулагч иргэдийг бухимдуулж байна.

Түүнчлэн бага орлоготой, ядуу бүлгийн иргэдийн болон хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг иргэдийн дундаж наслалт захиргааны ажил эрхэлдэг иргэдээс бага байна.

Монгол Улсын 2016 оны статистикийн мэдээгээр 127.8 мянган ажилгүй иргэд байна. Үүний 56.9 хувийг 15-34 насны залуучууд, 33.7 хувийг 35-49 насныхан эзэлж байгаа нь ажиллах хүчиний эгнээнд шинээр элсэн орж буй хүмүүс ажилгүйдэлд илүү өртөж байна. Иймд тэтгэврийн насыг нэмэгдүүлснээр залуучуудын ажиллах боломж хомсдоход хүрэхээр байна.

Төр, засгийн бодлогын хүмүүнлэг шинж байдлын хүрээнд хүүхэд төрүүлэх, өсгөж хүмүүжүүлэх, гэр бүлийн гишүүд, өндөр настныг асрах, халамжлахад эмэгтэйчүүдийн үүрэг их байдгийг хүлээн зөвшөөрч дийлэнх оронд эмэгтэйчүүдийн тэтгэвэрт гарах насыг эрэгтэйчүүдийнхээс эрт тогтоож байна.

Иймд тэтгэврийн насыг жилд 3 сараар нэмэх, ердийн нөхцөлөөр эмэгтэйчүүд 55, эрэгтэйчүүд 60 насандаа, мөн хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр 45-55 насанд хүрсэн даатгуулагч өөрөө хүсвэл тэтгэвэр тогтоолгох эрхийг хуульчлах шаардлагатай байна.

2. Тэтгэвэр тогтоолгох хөдөлмөрийн хөлсийг даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх аль дуртай дараалсан 5 жилд төлсөн шимтгэлээс тооцож гаргасан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тооцож байна. Нийгмийн даатгалын тогтолцоотой ихэнх улс оронд энэ хугацааг доод тал нь 10 жил, улмаар шимтгэл төлсөн бүх жилүүдийн цалингаас тооцож байна.

Одоогийн хуулийн заалт нь иргэд даатгуулагчдыг тэтгэвэрт гарах насанд ойртох үедээ 5 жил дараалан шимтгэлээ өндрөөр төлж, бусад жилүүдийн цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон төлж байгаа нь тэтгэврийн сангийн орлого багасаж, тэтгэврийн зардал, улмаар сангийн алдагдал нэмэгдэхэд нөлөөлж байна.

Иймд энэхүү дараалсан 5 жилийн хугацааг аажмаар буюу 2019 онд 1 жилээр, 2020 онд 1 жилээр нэмж 7 жил болгох шаардлагатай байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Дээр дурдсан үндэслэл шаардлагыг харгалзан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн зарим хэсэг, заалтад холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тусгана.

Гурав. Хууль батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар ахмадуудын орлогын баталгаа сайжрах, тэтгэврийн тогтолцооны шударга байдал нэмэгдэх, тэтгэврийн сангийн алдагдлыг бууруулах зэрэг нийгэм, эдийн засгийн эерэг үр дагавар бий болно.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид

нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлд тусгагдсан нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан “Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Хууль хүчингүй болсонд тооцох тухай”, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”, “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”, “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай” хуулийн төслийг тус тус боловсруулна.

--- oOo ---

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1. Үндэсний статистикийн хорооноос гаргасан "Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо"-оор одоо Монгол эрэгтэй хүний 60 наснаас хойш амьдрах хугацаа 17.06 жил, эмэгтэй хүний 55 наснаас хойш амьдрах хугацаа 25.38 жил байгаа бол энэ үзүүлэлт 2040 онд эрэгтэй 20.94 жил, эмэгтэй 55 наснаас хойш 28.71 жил болж жилд дунджаар 1.6-2 сараар нэмэгдэхээр байна.

Нийгмийн даатгалын болон халамжийн тухай хуулиудад 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан өөрчлөлтөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох насыг жилд 6 сараар буюу таван насаар 65 насанд хүргэхээр шийдвэрлэсэн нь дээрх тооцоололтой харьцуулахад З дахин өндөр байхын зэрэгцээ монгол хүний дундаж наслалтын өсөлттэй нийцэхгүй байна. Энэ нь тэтгэвэр тогтоолгох нас ойртож, хүлээлт үүссэн даатгуулагч иргэдийг бухимдуулж байна.

Түүнчлэн бага орлоготой, ядуу бүлгийн иргэдийн болон хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг иргэдийн дундаж наслалт захиргааны ажил эрхэлдэг иргэдээс бага байна.

Монгол Улсын 2016 оны статистикийн мэдээгээр 127.8 мянган ажилгүй иргэд байна. Үүний 56.9 хувийг 15-34 насны залуучууд, 33.7 хувийг 35-49 насныхан эзэлж байгаа нь ажиллах хүчний эгнээнд шинээр элсэн орж буй хүмүүс ажилгүйдэлд илүү өртөж байна. Иймд тэтгэврийн насыг нэмэгдүүлснээр залуучуудын ажиллах боломж хомсдоход хүргэхээр байна.

Төр, засгийн бодлогын хүмүүнлэг шинж байдлын хүрээнд хүүхэд төрүүлэх, өсгөж хүмүүжүүлэх, гэр бүлийн гишүүд, өндөр настныг асрах, халамжлахад эмэгтэйчүүдийн үүрэг их байдгийг хүлээн зөвшөөрч дийлэнх оронд эмэгтэйчүүдийн тэтгэвэрт гарах насыг эрэгтэйчүүдийнхээс эрт тогтоож байна.

Иймд тэтгэврийн насыг жилд 3 сараар нэмэх, ердийн нөхцөлөөр эмэгтэйчүүд 55, эрэгтэйчүүд 60 насандаа, мөн хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр 45-55 насанд хүрсэн даатгуулагч өөрөө хүсвэл тэтгэвэр тогтоолгох эрхийг хуульчлах шаардлагатай байна.

2. Тэтгэвэр тогтоолгох хөдөлмөрийн хөлсийг даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх аль дуртай дараалсан 5 жилд төлсөн шимтгэлээс тооцож гаргасан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тооцож байна. Нийгмийн даатгалын тогтолцоотой ихэнх улс оронд энэ хугацааг доод тал нь 10 жил, улмаар шимтгэл төлсөн бүх жилүүдийн цалингаас тооцож байна.

Одоогийн хуулийн заалт нь иргэд даатгуулагчдыг тэтгэвэрт гарах насанд ойртох үедээ 5 жил дараалан шимтгэлээ өндрөөр төлж, бусад жилүүдийн цалинг

хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон төлж байгаа нь тэтгэврийн сангийн орлого багасаж, тэтгэврийн зардал, улмаар сангийн алдагдал нэмэгдэхэд нөлөөлж байна.

Иймд энэхүү дараалсан 5 жилийн хугацааг аажмаар буюу 2019 онд 1 жилээр, 2020 онд 1 жилээр нэмж 7 жил болгох шаардлагатай байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .. дугаар
сарын ..-ний өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "60 нас хүрсэн" гэсний дараа "эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "55" гэснийг "50" гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалтын "55 нас хүрсэн бол" гэснийг "50 нас хүрсэн бол өөрийн хүсэлтээр" гэж, мөн хэсгийн 2 дахь заалтын "эрэгтэй 55 нас" гэснийг "эрэгтэй 50 нас" гэж, "эмэгтэй 50 нас хүрсэн бол" гэснийг "эмэгтэй 45 нас хүрсэн бол тус тус өөрийн хүсэлтээр" гэж, 22 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн "5" гэснийг "7" гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "таван" гэснийг "долоон" гэж, 2 дахь заалтын "таван" гэснийг "долоон" гэж, "60-д хуваана" гэснийг "84-д хуваана." гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2018 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрднө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ..дүгээр
сарын ..-ний өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн "заасны дагуу" гэсний дараа "бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоосон" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтын "65" гэснийг "эрэгтэй 60, эмэгтэй 55" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2018 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ..дүгээр
сарын ..-ний өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2018 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .. дүгээр
сарын ..-ний өдөр

Улаанбаатар
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН
САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ, ХУУЛИЙН ЗҮЙЛ, ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ
ТУХАЙ ХУУЛИУДЫГ ХЭРЭГЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 1997 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд доор дурдсан агуулгатай 6¹, 6² дугаар зүйл тус тус нэмсүгэй:

1/ 6¹ дүгээр зүйл:

"6¹ дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан өндөр насын тэтгэврийг өөрийн хүсэлтээр эрэгтэй 60 нас, эмэгтэй 55 насандаа тогтоолгох даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих доод хугацааг 2038 он хүртэл жил бүр 3 сараар нэмэгдүүлнэ."

2/ 6² дугаар зүйл:

"6² дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн өндөр насын тэтгэвэр тогтооход баримтлах хөдөлмөрийн хэлс, түүнтэй адилтгах орлогын дараалсан хугацаа 2019 онд 6 жил, 2020 онд 7 жил, өндөр насын тэтгэвэр тогтооход баримтлах хөдөлмөрийн хэлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийн хуваагдах сарын тоо 2019 онд 72 сар, 2020 онд 84 сар байна."

2 дугаар зүйл. 1997 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай

хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"2 дугаар зүйл.Өндөр насын тэтгэвэр тогтоолгох насын болзлыг доор дурдсанаар тогтооно:

1/ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрэгтэй даатгуулагчийн өндөр насын тэтгэвэр тогтоолгох нас:

Эрэгтэй даатгуулагчийн төрсөн он	Өндөр насын тэтгэвэр тогтоох нас
1957 ба түүнээс өмнө	60 нас
1958	60 нас 3 сар
1959	60 нас 6 сар
1960	60 нас 9 сар
1961	61 нас
1962	61 нас 3 сар
1963	61 нас 6 сар
1964	61 нас 9 сар
1965	62 нас
1966	62 нас 3 сар
1967	62 нас 6 сар
1968	62 нас 9 сар
1969	63 нас
1970	63 нас 3 сар
1971	63 нас 6 сар
1972	63 нас 9 сар
1973	64 нас
1974	64 нас 3 сар
1975	64 нас 6 сар
1976	64 нас 9 сар
1977 ба түүнээс хойш	65 нас

2/ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан эмэгтэй даатгуулагчийн өндөр насын тэтгэвэр тогтоолгох нас:

Эмэгтэй даатгуулагчийн төрсөн он	Өндөр насын тэтгэвэр тогтоох нас
1962 ба түүнээс өмнө	55 нас
1963	55 нас 3 сар
1964	55 нас 6 сар
1965	55 нас 9 сар
1966	56 нас

1967	56 нас 3 сар
1968	56 нас 6 сар
1969	56 нас 9 сар
1970	57 нас
1971	57 нас 3 сар
1972	57 нас 6 сар
1973	57 нас 9 сар
1974	58 нас
1975	58 нас 3 сар
1976	58 нас 6 сар
1977	58 нас 9 сар
1978	59 нас
1979	59 нас 3 сар
1980	59 нас 6 сар
1981	59 нас 9 сар
1982	60 нас
1983	60 нас 3 сар
1984	60 нас 6 сар
1985	60 нас 9 сар
1986	61 нас
1987	61 нас 3 сар
1988	61 нас 6 сар
1989	61 нас 9 сар
1990	62 нас
1991	62 нас 3 сар
1992	62 нас 6 сар
1993	62 нас 9 сар
1994	63 нас
1995	63 нас 3 сар
1996	63 нас 6 сар
1997	63 нас 9 сар
1998	64 нас
1999	64 нас 3 сар
2000	64 нас 6 сар
2001	64 нас 9 сар
2002 ба түүнээс хойш	65 нас

3 дугаар зүйл. 1997 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 6 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Малчны тэтгэврийг тогтоох, тэтгэврийн насыг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах журмыг Засгийн газар батална.

5 дугаар зүйл. Энэ хуулийг 2018 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .. дүгээр
сарын ..-ний өдөр

Улаанбаатар
хот

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "дараалсан 5 жилийн цалин хөлсний нийлбэрийг 60-д" гэснийг "дараалсан 7 жилийн цалин хөлсний нийлбэрийг 84-т" гэж, "5 хүртэл жил" гэснийг "7 хүртэл жил" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2018 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .. дүгээр
сарын ..-ний өдөр

Улаанбаатар
хот

**ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ
МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтооход баримтлах сарын цалин хөлсний дараалсан жил нь 2019 онд 6 жил, 2020 онд 7 жил, цалин хөлсний нийлбэрийн хуваагдах сарын тоо 2019 онд 72 сар, 2020 онд 84 сар байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2018 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд оорчлолт оруулах тухай,
Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд иэмэлт,
оорчлолт оруулах тухай болон дагалдах бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын
төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдээн хуралдаан болон байнгын хороодоор
холцлуулж ажлын хэсгийн нэрс**

№	Нэр	Албан тушаал
1	Ч.Хүрэлбаатар	Сангийн сайд
2	С.Наранцогт	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг хариуцаач. төрийн сангийн газрын дарга
3	Ж.Ганбат	Сангийн яамны төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
4	Д.Өлзийсайхан	Сангийн яамны төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга
5	М.Санжаадорж	Сангийн яамны төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн
6	Э.Номинэрдэн	Сангийн яамны төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн
7	Б.Тэлмүүн	Сангийн яамны төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн
8	Б.Анар	Сангийн яамны төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн
9	У.Мөнхзул	Сангийн яамны төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн
10	Э.Санал	Сангийн яамны төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн

ЗАСГИЙН ГАЗАР